



Иргэний нисэхийн дүрэм — 174

**Нисэхийн цаг уурын үйлчилгээний
байгууллагын гэрчилгээжүүлэлт**

Дүрмийн зорилго

ИНД-174 нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- иргэний нисэхэд цаг уурын үйлчилгээ үзүүлэх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны;
- нисэхийн цаг агаарын үндсэн мэдээгээр хангах нөхцөлийн.

Энэхүү баримт бичиг нь 2023 оны Иргэний нисэхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын шинэчлэн боловсруулсан ИНД-174 дүрмийн хувилбар бөгөөд зөвхөн ишлэлийн зорилгоор ашиглана. Зам, тээврийн сайдын баталсан албан ёсны хувилбарын хувийг эрх зүйн нэгдсэн мэдээллийн www.legalinfo.mn портал болон ИНЕГ-аас авах боломжтой.

Мэдээлэл

Энэхүү дүрэм нь Зам, тээврийн сайдын 2025 оны 09 сарын 30 өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдан хүчин төгөлдөр болсон. Энэхүү хувилбар нь шинэчлэгдэн батлагдсан дүрмийн анхны хэвлэл болно.

Гарчиг

А Бүлэг — Ерөнхий зүйл	4
174.1. Зорилго	4
174.3. Нэр томьёо ба товчлол	4
174.5. Гэрчилгээний шаардлага	4
174.6. Цаг агаарын мэдээ	4
174.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах	5
174.9. Гэрчилгээ олгох	5
174.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх	5
174.13. Гэрчилгээний хугацаа	5
174.15. Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах	6
В Бүлэг — Гэрчилгээжүүлэлтийн шаардлага	7
174.51. Ажилтанд тавигдах шаардлага	7
174.53. Ажиглалтын талбайд тавигдах шаардлага	8
174.55. Холбооны системд тавигдах шаардлага	8
174.57. Цаг уурын мэдээг хүлээн авахад тавигдах шаардлага	8
174.59. Цаг уурын мэдээлэл боловсруулан гаргахад тавигдах шаардлага	10
174.61. Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага	10
174.63. Баримт бичиг	10
174.64. Зохицуулалтын шаардлага	11
174.65. Бататгах, хуваарьт үзлэг, шалгалт болон хэмжилт тохируулга	11
174.67. Цаг уурын мэдээлэл гаргах	12
174.69. Цаг уурын алба болон тоног төхөөрөмжийн төлөв байдлыг мэдээлэх	12
174.71. Осол, зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах	13
174.73. Тоног төхөөрөмжийн доголдол болон алдаатай мэдээлэл	13
174.75. Бүртгэл	14
174.77. Чанарын менежментийн тогтолцоо	15
174.79. НЦУҮБ-ын Ерөнхий заавар	15
С Бүлэг — Үйл ажиллагааны шаардлага	18
174.101. Байнгын хэрэгжилт	18
174.103. Үйл ажиллагааны заавар	18
174.105. [Нөөц]	19
174.107. Гэрчилгээ эзэмшигчид тавигдах хязгаарлалт	19
174.109. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт	19

А Бүлэг — Ерөнхий зүйл

174.1. Зорилго

(а) Энэ дүрмээр дараах харилцааг зохицуулна:

- (1) нисэхэд цаг уурын үйлчилгээ үзүүлэх байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны шаардлага;
- (2) нисэхийн цаг агаарын мэдээгээр хангах нөхцөлийн шаардлага.

174.3. Нэр томьёо ба товчлол

(а) Энэ дүрэмд хэрэглэсэн нэр томьёо болон товчлолыг ИНД-1 Нэр томьёоны тайлбарт тусгасан.

174.5. Гэрчилгээний шаардлага

(а) Аливаа этгээд нь энэ дүрмийн дагуу олгосон Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага (цаашид “НЦУҮБ” гэх)-ын гэрчилгээний эрхийн хүрээ болон нөхцөлд заагаагүй нисэхийн цаг уурын үйлчилгээг үзүүлэхгүй байх үүрэгтэй.

(б) Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч (цаашид “Дарга” гэх) Монгол Улсын агаарын навигацийн системтэй харилцан ажиллах зорилгоор цаг уурын албаны сүлжээгээр хангагдсан, цаг уурын нэг, эсхүл хэд хэдэн үйлчилгээ үзүүлэх чадвартай байгууллагыг нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрч, гэрчилгээ олгож болно.

174.6. Цаг агаарын мэдээ

(а) Цаг агаарын мэдээгээр хангадаг этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) тухайн хийж байгаа ажиглалтад үзлэг, шалгалт хийсэн төхөөрөмжийг ашиглах;
- (2) тухайн төхөөрөмжийг шалгах тогтолцоог хэрэгжүүлэх;
- (3) цаг агаарын мэдээгээр хангах сургалтад хамрагдсан байх.

174.7. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

(а) НЦУУБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24174/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт Даргад хүргүүлнэ:

- (1) 174.79-д шаардсан Ерөнхий заавар;
- (2) төлбөрийн баримт.

174.9. Гэрчилгээ олгох

(а) Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь НЦУУБ-ын гэрчилгээ эзэмших эрхтэй:

- (1) хүсэлт гаргагч В Бүлэгт заасан шаардлагыг хангасан;
- (2) хүсэлт гаргагч болон 174.51(а)(1), (2)-т шаардсан удирдах ажилтнууд нь тохирох зөв хүн байх;
- (3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

174.11. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

(а) НЦУУБ-ын гэрчилгээнд тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгогдсон тоног төхөөрөмжийн төрлийг заана.

(б) Энэ дүрмийн 174.107-г харгалзан, НЦУУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд зөвшөөрсөн цаг уурын үйлчилгээ, цаг уурын үйлчилгээнд ашигладаг цаг уурын мэдээлэл бүрийг Ерөнхий зааварт тусгагдсан агаарын зай, газар нутагт үзүүлнэ.

174.13. Гэрчилгээний хугацаа

(а) НЦУУБ-ын гэрчилгээг 5 жилээс ихгүй хугацаагаар олгож, эсхүл гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгаж болно.

(б) НЦУУБ-ын гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дуусах, түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна.

(с) НЦУУБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон тохиолдолд гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

(d) Гэрчилгээг түдгэлзүүлэх шийдвэр гарсан тохиолдолд НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

174.15. Гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах

(a) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас хамгийн багадаа 30 хоногийн өмнө САА 24174/01 маягтыг бөглөж, төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлэх үүрэгтэй.

В Бүлэг — Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

174.51. Ажилтанд тавигдах шаардлага

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах этгээдийг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

- (1) Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон дараах удирдах ажилтан:
 - (i) энэ дүрэмд заагдсан үйл ажиллагааны шаардлага, стандартыг хангах зорилгоор байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх бүх үйл ажиллагааг тухайн байгууллагын хэмжээнд санхүүжүүлэх, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй;
 - (ii) энэ дүрэмд заасан шаардлага, стандартыг хангаж байгааг хүсэлт гаргагчийн өмнөөс бүрэн хариуцах;
- (2) Гүйцэтгэх захирлын өмнө дараах үүрэг хариуцлага хүлээсэн удирдах ажилтнууд:
 - (i) тухайн хүсэлт гаргагч байгууллага нь Ерөнхий заавраа дагаж мөрдөж байгааг бататгах;
 - (ii) 174.77-д шаардсан чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтийг хангах;
- (3) Ерөнхий зааварт заасан цаг уурын үйлчилгээг үзүүлэхийн тулд цаг уурын алба болон тоног төхөөрөмжийг төлөвлөх, ажиллуулах, хяналт тавих, үзлэг шалгалт хийх, гэрчилгээжүүлэх хангалттай тооны ажилтан.

(аа) Энэ зүйлийн (а)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон чанарын менежментийн тогтолцоотой холбоотой ур чадвар, туршлагаа нотолсон байх үүрэгтэй.

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) дараах ажилтнуудын сургалтын болон ур чадварын үнэлгээ хийх журмыг тогтоох:
 - (i) Ерөнхий зааварт заасан тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах;

- (ii) цаг уурын мэдээллийг боловсруулах болон түгээхэд хяналт тавих;
- (2) ажилтны ур чадварыг хадгалах журмыг тогтоох;
- (3) ажилтанд тухайн үйлчилгээг гүйцэтгэх эрхийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох.

174.53. Ажиглалтын талбайд тавигдах шаардлага

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах журамтай байна:

- (1) Ерөнхий зааварт заасан цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийг:
 - (i) хууль бус, эсхүл санамсаргүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэхээр боловсруулсан аюулгүйн хамгаалалтын арга хэмжээний дагуу ажиглалтын талбайд байршуулж, тохируулсан байх;
 - (ii) үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор тохирсон цахилгаан хангамж болон хэрэгсэлтэй байх;
- (2) Ерөнхий зааварт заасан цаг уурын тоног төхөөрөмж бүр нь Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц (цаашид “Конвенц” гэх)-ын Хавсралт 3-т заасан стандартыг хангасан байршилд суурилуулсан, цаг уурын нөхцөлийг үнэн зөв байхыг бататгах шалгалт баталгаажилт, засвар үйлчилгээ хийсэн байх.

174.55. Холбооны системд тавигдах шаардлага

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт заасан цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийг төлөвлөсөн цаг уурын мэдээллээр хангаж чадах холбооны систем болон журамтай байна.

(b) Холбооны систем нь дамжуулж байгаа цаг уурын мэдээллийн хэмжээ болон үндсэн шинжийг дамжуулалтын саатлаас шалтгаалан тухайн цаг хугацааны өмнөх цаг уурын мэдээлэл хүчингүй болдоггүй байхаар зохицуулах чадвартай байна. -

174.57. Цаг уурын мэдээг хүлээн авахад тавигдах шаардлага

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээнд тохирсон цаг уурын мэдээг хүлээн авах журамтай байна.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан журамд дараах шаардлагыг тусгасан байна:

- (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан урьдчилсан мэдээний үйлчилгээ үзүүлдэг цаг уурын алба болон тоног төхөөрөмж нь тухайн хүсэлт гаргагчийн хариуцсан урьдчилсан мэдээний бүсэд олон жилийн дундаж, бодит ажиглалтын болон бусад цаг уурын мэдээллийг байнга ашиглах боломжтой байх;
- (2) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын зааварчилгаа өгөх үйлчилгээг биечлэн, эсхүл мэдээллийн бусад хэрэгсэл ашиглан үзүүлдэг цаг уурын алба болон тоног төхөөрөмж нь тухайн зааварчилгааг өгөхөд тохирсон дэлгэц болон зааварчилгааны эх үүсвэрийг ашиглах боломжтой байх;
- (3) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын мэдээний үйлчилгээ үзүүлдэг цаг уурын алба болон тоног төхөөрөмж нь тохирсон, цаг уурын мэдээгээр цаг хугацаанд нь хангахад шаардлагатай ажиглалтын системтэй байх;
- (4) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын ажиглалтын үйлчилгээ үзүүлдэг цаг уурын алба нь тохирсон, цаг уурын ажиглалтын үйлчилгээгээр цаг хугацаанд нь хангахад шаардлагатай цаг уурын мэдээлэлтэй байх;
- (5) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан уур амьсгалын мэдээний үйлчилгээ үзүүлдэг цаг уурын алба болон тоног төхөөрөмж нь уур амьсгалын мэдээ бэлтгэхэд шаардлагатай цаг уурын мэдээлэлтэй байх.
- (6) Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ (цаашид “НХҮ” гэх)-ний байгууллагаар дамжуулан агаарын хөлгөөс хүлээн авах дараах мэдээллийг багтаасан цаг уурын тусгай мэдээлэлтэй байх:
 - (i) дэлбэрэхийн өмнөх галт уулын идэвхжил;
 - (ii) галт уулын дэлбэрэлт;
 - (iii) галт уулын үнсэн үүл;
 - (iv) атмосферт цацраг идэвхт материал, эсхүл хорт бодис цацагдах.

174.59. Цаг уурын мэдээлэл боловсруулан гаргахад тавигдах шаардлага

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) Ерөнхий зааварт заасан цаг уурын үйлчилгээ бүрийн хувьд боловсруулан гаргах цаг уурын мэдээлэл нь Конвенцын Хавсралт 3-т заасан техникийн тодорхойлолтыг хангасан байх;
- (2) боловсруулан гаргах цаг уурын мэдээллийн стандарт болон форматыг Конвенцын Хавсралт 3 болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан баримт бичиг PANS-MET Doc 10157-д нийцүүлэн тогтоох.

(b) Хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт заасан цаг уурын алба болон тоног төхөөрөмжөөс гаргасан цаг уурын мэдээлэл нь энэ зүйлийн (а)(2)-ын дагуу тогтоосон стандарт болон форматад нийцсэн байгааг бататгах журамтай байна.

174.61. Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь цаг уурын мэдээг хүлээн авах, эмхэтгэх, тооцоолох, ашиглах, эсхүл түгээхэд хэрэглэдэг цахим өгөгдлийг боловсруулдаг бүх тоног төхөөрөмж нь цаг уурын болон холбогдох мэдээллийн таарц, нарийвчлал нь тухайн цаг хугацаандаа тохирсон, мөн хүчин чадалтай болохыг бататгах журамтай байна.

174.63. Баримт бичиг

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт заасан цаг уурын үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах цаг уурын албаны журам, тоног төхөөрөмжийн заавар, техникийн стандарт болон зөвлөмж, үйл ажиллагааны заавар, бусад баримт бичгийн хувийг хадгална.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (а)-д шаардсан баримт бичгийг хянах журамтай байна. Энэ журам нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) баримт бичгийг гаргахаас өмнө холбогдох удирдах ажилтан хянаж, зөвшөөрөх;
- (2) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай холбогдох бүх баримт бичгийн хүчинтэй

хувийг шаардлагатай бүх байрлалд ажилтан авч ашиглахад бэлэн байлгах;

- (3) хүчингүй болсон баримт бичгийг боловсруулж гаргасан, эсхүл ашиглаж байгаа цэг бүрээс нэн даруй хураан авах;
- (4) тухайн баримт бичгийн өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, баталгаажуулах;
- (5) хугацаа нь дууссан хэвлэлтийг ашиглахаас сэргийлж, баримт бичгийн хуудас бүрийн хүчинтэй хувийг таньж тогтоох.

174.64. Зохицуулалтын шаардлага

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь НХҮ-ний байгууллагатай харилцан ажиллагааны зохицуулалтын гэрээтэй байна.

174.65. Бататгах, хуваарьт үзлэг, шалгалт болон хэмжилт тохируулга

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журамтай байна:

- (1) хүсэлт гаргагч хүлээж авсан болон түгээж байгаа цаг уурын мэдээллээ байнга нягталж бататгадаг байх;
- (2) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын алба бүрд хугацаат үзлэг, шалгалт хийх;
- (3) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан тоног төхөөрөмж бүрд хугацаат үзлэг, шалгалт, хэмжилт тохируулга хийх.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан журам нь дараах шаардлагыг бататгасан байна:

- (1) цаг уурын мэдээллийг байнга бататгахад шаардлагатай тогтолцоо нь тухайн цаг уурын мэдээллийг бататгахад шаардлагатай хүчин чадалтай ба бүрэн ажилладаг байх;
- (2) цаг уурын алба бүрд үзлэг, шалгалт хийхэд шаардлагатай үзлэг, шалгалтын төхөөрөмж, системийг ажилтан авч ашиглахад бэлэн байлгах;
- (3) холбогдох үзлэг, шалгалт, хэмжилт болон хэмжилтийн төхөөрөмж, систем нь тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалт, хэмжилт тохируулга хийх ажилтан авч ашиглахад бэлэн байх;

- (4) үзлэг, шалгалт, хэмжилт болон хэмжилтийн төхөөрөмж, систем нь тухайн хийж байгаа үзлэг, шалгалт, хэмжилтийн шаардлага хангахаар оновчтой ба нарийвчлалтай байх;
- (5) иж бүрдэлд орсон, эсхүл нэмж суурилуулсан хүрээлэн буй орчныг тандах мэдрүүр нь аль болох боломжит байдлаар найдвартай, үнэн зөв ба төлөөлөхүйц цаг уурын мэдээлэл өгдөг байхаар бүх цаг уурын тандан мэдрэх тоног төхөөрөмжид хэмжилт тохируулга хийж, ажлын горимд оруулсан байх.

174.67. Цаг уурын мэдээлэл гаргах

(a) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журамтай байна:

- (1) Ерөнхий зааварт заасан цаг уурын алба бүрээс цаг уурын мэдээлэл гаргах;
- (2) Ерөнхий зааварт заасан тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам нь үйл ажиллагааг хянах, цаг уурын мэдээллийг гаргах эрх бүхий этгээд болон цаг уурын тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах эрх бүхий этгээдийг 174.51(b)-д шаардсан журмын дагуу ур чадвартай болохыг үнэлгээ хийж бататгадаг байна.

174.69. Цаг уурын алба болон тоног төхөөрөмжийн төлөв байдлыг мэдээлэх

(a) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт заасан цаг уурын алба, эсхүл тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны төлөв байдлын өөрчлөлт болон холбогдох үйл ажиллагааны мэдээллийг тухайн цаг уурын үйлчилгээг хэрэглэгчдэд мэдэгдэх журамтай байна.

(b) Хүсэлт гаргагч энэ зүйлийн (a)-ийн дагуу тогтоосон журам нь дараах шаардлага хангасан болохыг бататгах үүрэгтэй:

- (1) хүсэлт гаргагч нь Монгол Улсын агаарын навигацийн, эсхүл НХҮ-г дэмжих цаг уурын үйлчилгээ бүрийн үйл ажиллагааны мэдээллийг Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (цаашид “AIP” гэх)-д хэвлэн нийтлүүлэх зорилгоор Нисэхийн мэдээллийн үйлчилгээ (цаашид “НМҮ” гэх)-ний байгууллагад хүргүүлдэг байх;
- (2) цаг уурын алба, эсхүл тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд орсон тухайн өөрчлөлт нь агаарын навигацийн үйлчилгээ,

нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй тохиолдолд өөрчлөлтийг яаралтай мэдээлдэг байх. AIP-д хэвлэн нийтэлсэн цаг уурын алба болон тоног төхөөрөмжийн хувьд тэдгээрийн үйл ажиллагааны төлөв байдлын аливаа өөрчлөлттэй холбоотой мэдээллийг NOTAM-аар зарлуулахаар НМҮ-ний байгууллагад заавал хүргүүлдэг байх.

174.71. Осол, зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь осол, зөрчилд өртсөн агаарын хөлөг, эсхүл НХҮ-нд ашигласан байж болох өөрийн түгээсэн цаг уурын мэдээллийн таарц, нарийвчлал болон тухайн цаг хугацаандаа тохирсон болохыг шалгах журмыг тогтоосон байна.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан журам нь дараах шаардлагыг бататгасан байна:

- (1) осол, зөрчлийн талаар хүсэлт гаргагч байгууллагад мэдэгдсэний дараа шалгалтыг нэн даруй гүйцэтгэх;
- (2) цаг уурын мэдээллийн хувийг дараагийн шинжлэн шалгах ажиллагаанд ашиглахад боломжтой байлгах зорилгоор аюулгүй газар хадгалах.

174.73. Тоног төхөөрөмжийн доголдол болон алдаатай мэдээлэл

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журамтай байна:

- (1) алдаатай цаг уурын мэдээллийг таньж тогтоох, бүртгэх, мэдэгдэх, шинжлэн шалгах болон залруулах;
- (2) алдаатай цаг уурын мэдээллээр хангахад хүргэж болох Ерөнхий зааварт заасан тоног төхөөрөмж болон цаг уурын үйлчилгээнд илэрсэн доголдлыг таньж тогтоох, бүртгэх, мэдэгдэх, шинжлэн шалгах болон залруулах;
- (3) алдаатай цаг уурын мэдээллийг хүлээн авсан бүх хэрэглэгчдэд цаг алдалгүй мэдэгдэх;
- (4) 72 цагийн дотор засаж залруулж чадахгүй тоног төхөөрөмжийн доголдлыг 12 цагийн дотор Даргад мэдэгдэх;
- (5) Дарга шаардсан тохиолдолд, тухайн тоног төхөөрөмжийн доголдлын төлөв байдлын талаар мэдээлэх.

174.75. Бүртгэл

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт заасан цаг уурын үйлчилгээгээр хангахад шаардлагатай бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах журамтай байна.

(b) Энэ зүйлийн (а)-д шаардсан журам нь дараах шаардлагыг бататгана:

- (1) 174.57-д шаардсан журмын дагуу цуглуулсан цаг уурын мэдээний өгөгдлийн бүртгэлтэй байх;
- (2) 174.59-ийн дагуу тогтоосон, бүх боловсруулан гаргасан цаг уурын мэдээллийн бүртгэлтэй байх;
- (3) энэ зүйлийн (b)(1) болон (2)-т заасан бүртгэлийг 60-аас доошгүй хоног, эсхүл Даргын шаардаж болох хугацаагаар хадгалдаг байх;
- (4) цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийн гүйцэтгэлийг баримтжуулах, түүний техник үйлчилгээ, үйлчилгээ болон бүтээгдэхүүний чанар, хугацаат үзлэг, шалгалт болон эдгээр ажиллагаа тус бүрийг хариуцсан ажилтны түүхийг эргэн тогтоох боломжоор хангах зорилгоор хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийн бүртгэлтэй байх;
- (5) 174.65-д шаардсан журмын дагуу бататгах, үзлэг шалгалт, хэмжилт тохируулга хийхэд ашигладаг төхөөрөмж болон системийн бүртгэлтэй байх. Бүртгэл нь тухайн төхөөрөмж болон системийн байршил, техник үйлчилгээ, тохируулгын шалгалтын түүхийг эргэн тогтоох боломжоор хангасан байна;
- (6) 174.73-т шаардсан журмын дагуу мэдээлсэн алдаатай цаг уурын мэдээлэл болон илрүүлсэн тоног төхөөрөмжийн доголдол бүрийн бүртгэлтэй байх. Бүртгэл нь алдаатай цаг уурын мэдээлэл, эсхүл тоног төхөөрөмжийн доголдол болон шинжлэн шалгах ажиллагааны үед илрүүлсэн дутагдлыг залруулах арга хэмжээг эргэн шалгах талаар дэлгэрэнгүй заасан байна;
- (7) [нөөц]
- (8) хүсэлт гаргагчийн цаг уурын мэдээллийг боловсруулах болон түгээхэд хяналт тавих, тухайн тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах эрх бүхий этгээдийн бүртгэлтэй байх. Бүртгэл нь тэдгээрийн ажлын туршлага, мэргэшил, сургалт, олгосон эрхийн мэдээллийг багтаасан байна;

- (9) бүх бүртгэл нь гаргацтай, байнгын арилдаггүй шинж чанартай байх;
- (10) энэ зүйлийн (b)(1) болон (2)-т шаардсанаас бусад бүх бүртгэлийг 1 жилээс доошгүй хугацаагаар, эсхүл цаг уурын үйлчилгээний гүйцэтгэлийн түүхийг үүсгэх зорилгоор Даргын шаардаж болох хугацаагаар хадгалдаг байх.

174.77. Чанарын менежментийн тогтолцоо

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.

174.79. НЦУҮБ-ын Ерөнхий заавар

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журам болон тогтолцооны дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) Дараах шаардлагыг хангасан болохыг бататган, хүсэлт гаргагч байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) Ерөнхий заавар нь байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тодорхойлох ба энэ дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулсан байх;
 - (ii) байгууллагын ажилтнууд Ерөнхий заавар, холбогдох бусад бүх журам, зааврыг байнга дагаж мөрддөг байх;
- (1A) 174.77-д шаардсан чанарын менежментийн тогтолцооны хувьд:
 - (i) ISO 9000 цуврал чанар баталгаажуулалтын стандартаар шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) НЦУҮБ-ын гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах хүсэлт гаргаагүй хүсэлт гаргагчийн хувьд чанарын менежментийн тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 174.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын албан тушаал, нэр;
- (3) 174.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын дараах үүрэг, хариуцлага:

- (i) хариуцсан чиг үүргийн хүрээнд тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл Иргэний нисэхийн ерөнхий газартай шууд харилцах асуудал;
 - (ii) чанарын менежментийн тогтолцооны хүрээнд хамаарах үүрэг хариуцлага;
- (4) 174.51(а)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (5) энэ зүйлийн (а)(7)(i)-д заасан цаг уурын албанд ажиллах тухайн байгууллагын ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (5А) байгууллагын хүрээнд чанарын менежментийн хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
- (6) гэрчилгээнд тусгагдсан цаг уурын үйлчилгээний жагсаалт;
- (7) дараах мэдээлэл бүхий жагсаалт:
- (i) хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа цаг уурын алба бүрийн байршил;
 - (ii) хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа, хэрэглэгчийг цаг уурын мэдээллээр шууд хангадаг тоног төхөөрөмж бүрийн байршил;
 - (iii) эдгээр цаг уурын алба болон тоног төхөөрөмж бүрийн үзүүлдэг цаг уурын үйлчилгээ;
 - (iv) эдгээр цаг уурын үйлчилгээнд хамрагддаг нутаг дэвсгэр болон агаарын зай;
- (8) 174.59(а)(1)-ийн дагуу ангилсан, хүсэлт гаргагчийн боловсруулан гаргасан цаг уурын мэдээллийн дэлгэрэнгүй болон 174.59(а)(2)-ын дагуу тогтоосон мэдээллийн стандарт болон формат;
- (9) 174.51(b)-д заасан ажилтны ур чадварыг хадгалах, үнэлгээ хийх журам;
- (10) 174.53-т заасан ажиглалтын талбайн журам;
- (11) 174.55-д заасан холбооны системийн шаардлага;
- (12) 174.57-д заасан цаг уурын мэдээний өгөгдөл цуглуулах журам;

-
- (13) 174.59-д заасан цаг уурын мэдээлэл боловсруулан гаргах журам;
 - (14) 174.61-д заасан тоног төхөөрөмжийн мэдээлэл;
 - (15) 174.63(b)-д заасан баримт бичгийг хянах журам;
 - (16) 174.65-д заасан бататгах, хугацаат үзлэг, шалгалт, хэмжилт тохируулга хийх журам;
 - (17) 174.67-д заасан цаг уурын мэдээлэл гаргах ба тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулах журам;
 - (18) 174.69-д заасан цаг уурын алба болон тоног төхөөрөмжийн төлөв байдлыг мэдэгдэх журам;
 - (19) 174.71-д заасан осол, зөрчлийн дараа цаг уурын мэдээллийг шалгах журам;
 - (20) 174.73-д заасан тоног төхөөрөмжийн доголдол болон алдаатай мэдээлэл;
 - (21) 174.75-д заасан бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах журам;
 - (22) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.
- (b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар Даргаар хүлээн зөвшөөрөгдсөн байна.

С Бүлэг — Үйл ажиллагааны шаардлага

174.101. Байнгын хэрэгжилт

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) энэ дүрмийн В Бүлгийн шаардлага болон стандартыг хангах;
- (2) Ерөнхий зааварт дэлгэрэнгүй заасан бүх журам болон тогтолцоог дагаж мөрдөх;
- (3) Ерөнхий зааварт заасан цаг уурын алба бүрд, тухайн зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгалах;
- (4) Ерөнхий зааврын холбогдох бүлгийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ ашиглах боломжтой байлгах;
- (5) САА 24174/01 маягтад шаардсан үйлчилгээ эрхлэх хаяг, утасны дугаар, факсын дугаар, эсхүл цахим шуудангийн хаягийн аливаа өөрчлөлтийг тухайн өөрчлөлт орсон өдрөөс хойш 28 хоногийн дотор Даргад мэдэгдэх.

174.103. Үйл ажиллагааны заавар

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт заасан цаг уурын алба бүрийг үйл ажиллагааны заавраар хангасан байна. Үйл ажиллагааны заавар нь цаг уурын алба болон холбогдох тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны болон техник үйлчилгээний журмыг тогтоох ба дараах мэдээллийг багтаасан байна:

- (1) хангаж байгаа цаг уурын мэдээлэл болон үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээ;
- (2) тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны хүлээн зөвшөөрөгдөх минимум үзүүлэлт болон стандарт;
- (3) шаардлагатай цаг уурын мэдээний минимум өгөгдөл;
- (4) боловсруулан гаргах цаг уурын мэдээлэл болон хангаж байгаа цаг уурын үйлчилгээний гүйцэтгэлийн болон чанарын минимум түвшин;
- (5) энэ хэсгийн (4)-т заасан минимум түвшнийг хэмжихэд шаардлагатай хэмжилтийн төхөөрөмж болон систем;

- (6) цаг уурын мэдээллийг гаргахад заавал мөрдөх шаардлагатай шалгалтын журам.

174.105. [Нөөц]**174.107. Гэрчилгээ эзэмшигчид тавигдах хязгаарлалт**

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах үйл ажиллагааг гүйцэтгэхгүй:

- (1) тухайн цаг уурын мэдээг гаргахад шаардлагатай цаг уурын мэдээний өгөгдөл байхгүй тохиолдолд цаг уурын мэдээллээр хангах; эсхүл
- (2) тухайн цаг уурын алба, эсхүл тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны үзүүлэлт нь холбогдох шаардлага хангаагүй тохиолдолд цаг уурын мэдээллээр хангах; эсхүл
- (3) тухайн цаг уурын мэдээллийн үнэн зөв байдлын хяналтын тогтолцоо нь бүрэн гүйцэд ажиллаагүй байх тохиолдолд цаг уурын мэдээллээр хангах; эсхүл
- (4) тухайн цаг уурын мэдээлэлтэй холбоотой, шаардлагатай баталгаажуулалт, үзлэг, шалгалт, хэмжилт тохируулгыг гүйцэд хийгээгүй тохиолдолд цаг уурын мэдээллээр хангах; эсхүл
- (5) тухайн цаг уурын мэдээллийн үнэн зөв байдалд эргэлзэх аливаа шалтгаан байгаа тохиолдолд цаг уурын мэдээллээр хангах.

174.109. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

(а) НЦУҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг тухайн байгууллага болон үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээний мэдээлэл үнэн зөв байхаар хийдэг болохыг бататгах үүрэгтэй.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг энэ дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгаа ба тухайн зааварт заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөж байгааг бататгах үүрэгтэй.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа тухайн зааврын нэмэлт өөрчлөлтийн хувийг цаг алдалгүй Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхийн өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:

- (1) 174.51(a)(1)-д заасан Гүйцэтгэх захирлыг өөрчлөх;
- (2) 174.51(a)(2)-д заасан удирдах ажилтныг өөрчлөх;
- (3) гэрчилгээ эзэмшигчийн үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээ;
- (4) гэрчилгээ эзэмшигчийн үзүүлж байгаа цаг уурын үйлчилгээнд хамрагддаг нутаг дэвсгэр болон агаарын зай;
- (5) чанарын менежментийн тогтолцоо (хэрэв тухайн өөрчлөлт нь нөлөө бүхий өөрчлөлт бол).

(e) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл түүнийг хийсний дараа тухайн гэрчилгээ эзэмшигчийн зайлшгүй дагаж мөрдөх нөхцөлийг Дарга тогтоож болно.

(f) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e)-гийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол, гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад цаг алдалгүй хүргүүлнэ.

(h) Нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий зааварт тусгах үүрэгтэй.

--oOo--